



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 31  
№50 (1395)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

|      |                                                                                   |      |
|------|-----------------------------------------------------------------------------------|------|
| 263. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх<br>тухай хуульд нэмэлт, өөрчлөлт<br>оруулах тухай | 2523 |
|------|-----------------------------------------------------------------------------------|------|

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

|      |                                                                           |            |      |
|------|---------------------------------------------------------------------------|------------|------|
| 264. | Тогтоолд нэмэлт оруулах тухай                                             | Дугаар 112 | 2525 |
| 265. | Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн,<br>даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 115 | 2529 |
| 266. | Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох,<br>чөлөөлөх тухай                    | Дугаар 116 | 2531 |

|         |       |       |
|---------|-------|-------|
| Тайлбар |       | • ᠑᠖᠑ |
| ᠑᠖᠑     | • ᠑᠖᠑ | • ᠑᠖᠑ |
| ᠑᠖᠑     | • ᠑᠖᠑ | • ᠑᠖᠑ |
| ᠑᠖᠑     | • ᠑᠖᠑ | • ᠑᠖᠑ |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

#### **1/14.9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх энэ зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр, эсхүл хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.”

#### **2/14.15 дугаар зүйл:**

**“14.15 дугаар зүйл.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх  
ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгчид таслан  
сэргийлэх арга хэмжээ авах**

1.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх энэ хуульд заасны дагуу яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, завсарлуулах, хэргийг түдгэлзүүлэх, тусгаарлах, буцаах, шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх үед яллагдагч, шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой прокурор, оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрт яллагдагч, шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсэн, өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэлийг тусгана.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.УЧРАЛ**

مصر مصر مصر

الحمد لله

١٤٤٥ هـ و ١٤٤٦ هـ - ١٤٤٧ هـ و ١٤٤٨ هـ

**சென்னை நகராட்சி நிர்வாகப் பேரவை**

[illegible]

જાહેરાત : ૧૦/૧૦/૨૦૧૯

[illegible]

**حصص حصص = ٤٦٠.٠٦**

[illegible][illegible][illegible][illegible]

دانشگاه تهران

ה'תשנ"ח

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 112

Улаанбаатар  
хот

### Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “08,” гэсний дараа “10 дугаар бүлгийн 1002.90.20, 1003.90.20, 1004.90.20, 1005.90.20 дахь үндэсний код, 11 дүгээр бүлгийн 11.01 дэх зүйл,” гэж, “22.09 дэх зүйл,” гэсний дараа “23 дугаар бүлгийн 23.02 дахь зүйл,” гэж тус тус нэмсүгэй.

2.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 10 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай дараах үндэсний код нэмсүгэй:

“

|  |            |                                                                                                                                                                                      |          |
|--|------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------|
|  | 1002.90.20 | Тэжээлийн хөх тариа                                                                                                                                                                  |          |
|  | 1003.90.20 | Тэжээлийн арвай                                                                                                                                                                      |          |
|  | 1004.90.20 | Тэжээлийн овьёос                                                                                                                                                                     |          |
|  | 1005.90.20 | Тэжээлийн эрдэнэшишийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор тус тус импортолсон бол | 5 хүртэл |

”

3.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 23 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 23.02 дахь зүйл нэмсүгэй:



“

|  |       |                                                                                                                                                                                                                                                                                                                          |             |
|--|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|
|  | 23.02 | Үр тариа ба буурцагт ургамлыг шигших, тээрэмдэх, эсвэл бусад боловсруулалт хийх явцад гардаг хорголжилсон, эсвэл хорголжлоогүй хивэг, үртэс болон бусад үлдэгдлийг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол | 5<br>хүртэл |
|--|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|

”

4.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 11 дүгээр бүлгийн “7 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “15” гэсний дараа “хүртэл” гэж, мөн бүлгийн “4 дүгээр сарын 1-нээс 7 дугаар сарын 1 хүртэл” гэсэн хугацаанд заасан албан татварын хувь, хэмжээний “5” гэсний дараа “хүртэл” гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.УЧРАЛ**

رسالة من

الحمد لله

۳۶۶ مستدر

٢٠٢٥ هـ و ١٤٤٦ هـ  
محرم الحرام ١٤٤٦ هـ - ١٠ محرم

مستند کو نیچر محفوظی

[illegible][illegible][illegible] $\gg$ [illegible]

»

[illegible]





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар  
хот

### **Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Пүрвээгийн Дэлгэрнаранг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг шинээр томилох хүртэл хугацаанд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, нарийн бичгийн дарга Даваанямын Даваа-Очирт даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.УЧРАЛ**

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

Бүртгэж байгаа үйлдвэр, ажлаас

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар  
хот

### **Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай**

Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Бядрангийн Лхагвасүрэнгийн бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.УЧРАЛ**

